ТӨРИЙН БАНК

## МӨНГӨН ШИЛЖҮҮЛЭГ / MONEY TRANSFER

| Он/YY | Сар/MM | Өдөр/DD |
|---|---|---|
| 2016 | 11 | 10 |

**Хүлээн авагчийн** /Beneficiary's:

| Банкны нэр / Bank name: | Дансны № / Account №: | Нэр (байгууллага эсвэл иргэн)/ Name (organization or individual): |
|---|---|---|
| Худалдаа хөгжлийн банк | 499026123 | АЙ ТИ ЗОН ХХК |
| Мөнгөн дүн тоогоор/ Amount: | Мөнгөн дүн үсгээр/ Amount in words: | Валют/ Currency: |
| 25,917,115.00 | хорин таван сая есөн зуун арван долоон мянга нэг зуун арван таван төгрөг | MNT |
| Гүйлгээний утга, бусад тэмдэглэл/ Details of payment: | | Нууц код/ Code: |
| УРЬДЧИЛГАА ТӨЛБӨР АТГ -С | | |

**Шилжүүлэгчийн** / Sender's

| Банкны нэр/ Bank name: | Дансны №/ Account №: | Нэр (байгууллага эсвэл иргэн)/ Name (organization or individual): |
|---|---|---|
| ТБ УБ ГУРВАН ЯАМ ТКАСС | 340004010398 | АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР |
| Мөнгөн дүн тоогоор/ Amount: | Валют/ Currency: | Гүйлгээний төрөл/ Transaction type |
| 10,656.71 | USD | 1073 Депозит - банк хоорондын шилжүүлэг хийх |

Тэмдэглэл/ Note: 340004010398 данснаас "Ай Ти Зон" ХХК-ний ХХБ-ны 499026123 дансанд 25'917'115 ₮ урьдчилгаа төлбөр

Тамга/ Stamp:

Баталгаат гарын үсэг/ Authorized signature:

1.................... 2.................... 3....................

Банкны тэмдэглэгээ/ For bank use only:

| Теллер № | Журнал № | Огноо | Гүйлгээний хураамж | Шилжүүлэгчийн биеийн байцаалтын төрөл № | Теллер гарын үсэг |
|---|---|---|---|---|---|
| 1757 | 615800167884 | 11/10/201 | | | |

---

**АЙ ТИ ЗОН ХХК**
Ай Ти Зон ХХК, 4-р давхар, Сити Тауэр, Сүхбаатарын талбай-5, 8-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14200, Монгол улс
УТАС: (976)-7731773.1; WWW.ITZONE.MN

ITZONE
Accelerate Your Success

## НЭХЭМЖЛЭХ

| | | | |
|---|---|---|---|
| ХЭНД: | Авлигатай тэмцэх газар | ДУГААР: | 16-TUV10-029 |
| ХАЯГ: | | ОГНОО: | 2016.11.02 |

| Д/д | Барааны нэр | Тоо | Нэгж үнэ | Нийт үнэ | Эцсийн үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1 | IZSLS-16/169 дугаартай гэрээний урьдчилгаа төлбөр | 1 | 25,917,115.00 ₮ | 25,917,115.00 ₮ | 25,917,115.00 ₮ |
| | | | | Нийт төлбөр /НӨАТ орсон/ | 25,917,115.00 ₮ |

ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА:

БАТАЛГААЖУУЛСАН: ______________________

/ Байгууллага хариуцсан худалдааны менежер

**Оффис:**
Ай-Ти-Зон ХХЗ Компани
4-давхар, City Tower байр
Сүхбаатарын талбай-2,
8-р хороо, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар-210620а,

**Банкны мэдээлэл**

| | |
|---|---|
| ХХБанк | 499026123 (₮) |
| Голомт банк | 1102612501 (₮) |
| Хаан банк | 5037071406 (₮) |
| Хас банк | 5000010323 (₮) |

**Үнийн саналын талаар лавлах**

| | |
|---|---|
| Борлуулагч: | Оюунжаргал |
| Оффисын утас: | |
| Гар утас: | 89101080 |
| И-мэйл: | |

БАТЛАВ: АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА, ЭРХЭЛСЭН КОМИССАР

..............................................
З.БААСАННЯМ

БАТЛАВ: АЙ ТИ ЗОН ХХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ

..............................................
У.НАРАНБААТАР

# ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Монгол Улс, Улаанбаатар хот 14250, Сүхбаатар дүүрэг,
5-р хороолол, Сөүлийн гудамж 41

болон

АЙ ТИ ЗОН ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Их Эзэн Чингис хааны нэрэмжит талбай 2, Сэнтрал Тауэр
Утас: (+976-11) 323705, Үйлчилгээний лавлах: (+976) 7731-2424, Факс: (+976-11) 312699
И-мэйл: crm@itzone.mn, Вэб: www.itzone.mn

Гэрээний № IZSLS 16/169/99

Since 1997
ITZONE
Accelerate Your Success

IZSLS/16/169

2016 оны 11 дугаар сарын 02-ны өдөр

Монгол Улс, Улаанбаатар хот

Энэхүү Худалдах, худалдан авах гэрээг (Цаашид "Гэрээ" гэх ) 2016 оны 11 дугаар сарын 2–ны өдөр /Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр/

Нэг талаас: 5120829 регистрийн дугаартай Авлигатай тэмцэх газар /Цаашид "Худалдан авагч" гэх/ түүнийг төлөөлж Тамгын хэлтсийн Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албаны ахлах ажилтан, ахлах комиссар Ц.Гомбодорж, нөгөө талаас: Улсын бүртгэлийн 9011048067 дугаартай "АЙ ТИ ЗОН" ХХК, / "Худалдагч" гэх/ РД:2113155, түүнийг төлөөлж Тэргүүн дэд захирал У.Наранбаатар нар нь /Цаашид хамтад нь "Талууд" гэх/хүсэл сонирхолоо бүрэн, чөлөөтэй илэрхийлж, дараахь нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

## 1. Гэрээний зорилго

Худалдагч нь стандартын дагуу үйлдвэрлэгдэж, чанарын шаардлага хангасан биет байдлын доголдолгүй, эрхийн зөрчилгүй, харилцан тохиролцсон тоо ширхэг бүхий бараа (цаашид "бараа" гэх) -г холбогдох баримт бичгийн хамт худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь худалдагчид гэрээнд заасан нөхцөлөөр төлбөр тооцоог гүйцэтгэхтэй холбоотой үүсэх харилцааг зохицуулна.

## 2. Гэрээний зүйл

Барааны нэр төрөл, тоо хэмжээ, түүнийг нийлүүлэх хугацаа, хүлээн авах газар зэргийг Хавсралт 01-д тодорхойлно. Бараа нь эрхийн зөрчилгүй, биет байдлын доголдолгүй байна. Бараа нь чанар, стандарт, эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангасан байх ба сав баглаа боодол нь эрүүл ахуйн стандартад нийцэх, эвдэрч гэмтэхээс хамгаалагдсан, аюулгүй тээвэрлэлтийн шаардлага хангасан байна.

## 3. Гэрээний хугацаа

Гэрээ нь 2016 оны 11 дугаар сарын 2 –ны өдрөөс 2016 оны 11 дүгээр сарын 9–ний өдөр хүртэл 7 хоног байна.

## 4. Барааны үнэ, төлбөр

Барааны үнийг Хавсралт 01-д тодорхойлох ба бараанд НӨАТ, тээврийн болон бусад зардлууд хүлээлгэн өгөхтэй холбогдох зардлууд орсон болно. Барааны үнэ нэмэгдэх, мөнгөний ханш унах, мөнгөн масштабд өөрчлөлт орсон нь энэхүү гэрээний үнийг өөрчлөх үндэс болохгүй.

## 5. Барааны төлбөр хийх нөхцөл

Гэрээний нийт үнийн дүн болох 64,792,788 /Жаран дөрвөн сая долоон зуун ерэн хоёр мянга долоон зуун наян найм/ төгрөгийг гэрээ байгуулагдсанаас хойш ажлын 2 хоногийн дотор 40 хувь буюу 25,917,115 төгрөг, гэрээнд заасан хугацааны дагуу барааг хүлээн авснаас хойш ажлын 2 хоногийн дотор үлдэгдэл 60 хувь буюу 38,875,673 төгрөгийг худалдагч талын Худалдаа хөгжлийн банкны 499026123 тоот дансанд шилжүүлнэ.

Талуудын гарын үсэг

Худалдан авагч: ____________ Худалдагч: ____________

**6. Барааг хүлээлгэн өгөх, доголдлыг арилгах**

Барааг Хавсралтад заасан хугацаанд нь болон газарт талууд гарын үсэг зурж хүлээлгэн өгсөн өдрөөс эхлэн барааг ашиглах, хадгалахтай холбоотой эрдсэл Худалдан авагчид шилжинэ. Энэхүү эрсдэл нь баталгаат хугацаанд хүлээх Худалдагчийн үүргийг хязгаарлах үндэслэл болохгүй. Бараа нь ил болон далд биет байдлын доголдолтой байх тохиолдолд падаанаас хасч тооцох буюу ижил төрлийн бараагаар Худалдан авагчийн анхны шаардлагын дагуу солино.

**7. Баталгаат хугацаа, хүлээх үүрэг**

Баталгаат хугацааг Хавсралтаар тодорхойлох ба бараа бүтээгдэхүүнд доголдол илэрвэл ажлын 14 хоногт багтаан доголдлыг арилгах буюу ижил төрлийн бараа бүтээгдэхүүнээр сольж өгөх үүрэгтэй.

**Мэдээлэл өгөх, тээвэрлэх, хүлээлгэн өгөх**

Худалдагч нь Барааны талаар үнэн зов, бүрэн мэдээллийг огох, шаардлагатай бол барааг хэрэглэх, ашиглах дэлгэрэнгүй заавар зөвлөмжийг Монгол хэл дээр бэлтгэж хүлээлгэн өгнө. Бараанд сав баглаа боодол, барааны аюулгүй байдлын хамгаалалтыг хийх, худалдан авагчид тээвэрлэн хүргэж өгөх, ачиж буулгах үүрэг, зардлыг Худалдагч хариуцна.

**8. Алданги**

Худалдагч нь бүтээгдэхүүнийг гэрээнд заасан хугацаанд худалдан авагчид шилжүүлээгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг худалдан авагчид төлнө. Худалдан авагч нь гэрээнд заасан үнийг хугацаанд нь төлбөрийг шилжүүлээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг худалдагчид төлнө.

**9. Давагдашгүй хүчин зүйл**

Гэрээний аль нэг тал гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй дараах нөхцөл байдал бий болсны улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцохгүй харин зайлшгүй асуудлыг зөвшилцөх, харилцан тохирох замаар шийдвэрлэнэ. Үүнд: гал түймэр, үер, газар хөдлөлт, салхи шуурга, хар салхи болон байгалын бусад аюулт үзэгдэл, дайн, халдлага, цэргийн дайралт, үймээн, самуун, цэргийн болон хууль бусаар булаан эзлэх, өмчийг хууль бусаар булаан авах, улсын орлого болгох, террорист үйл ажиллагаа, өмч хөрөнгийг нийгэмчлэх, засгийн газрын хориг арга хэмжээ, хорио цээр, ажил хаялт, цахилгаан эрчим хүчний тасалдал болон телефон холбоо эвдрэх, гэмтэл саатал, тасалдал бий болох, улсын хил тодорхойгүй хугацаагаар хаагдах зэрэг орно.

**10. Хариуцлага**

11.1 Гэрээнд заасан хугацаанаас хоцорч барааг нийлүүлсэн, доголдолтой, чанаргүй барааг хүлээлгэн өгсөнөөс бий болох аливаа хохирол, хариуцлагыг Худалдагч хүлээнэ.Алданги торгууль төлсөн нь Талуудыг хариуцлага болон учирсан хохирлыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй. Мөн гэрээ дуусгавар болох болон цуцлагдсан нь гэрээний үүрэг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Талуудын гарын үсэг

Худалдан авагч: ______________ Худалдагч: ______________

11.2 Худалдан авагч барааг ашиглахдаа ашиглалтын горимыг зөрчсөн, бараанд механик гэмтэл учируулсан зэрэг үйлдэл эс үйлдлийн улмаас гарсан барааны эвдрэл гэмтэл доголдлыг Худалдагч хариуцахгүй болно.

**11. Гэрээг цуцлах, дуусгавар болгох**

Энэхүү гэрээнд зааснаар эсхүл талууд харилцан тохиролцсоноор эсхүл аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн, удаа дараа биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачилгаар гэрээг шууд цуцалж болно.

**12. Маргааныг шийдвэрлэх**

Гэрээний хугацаанд болон түүнээс хойш үүсэх маргаантай асуудлыг хоёр тал харилцан зөвшилцөх байдлаар шийдэх. Зөвшилцөлд эс хүрсэн тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Шүүхээр шийдвэрлүүлнэ.

**13. Нууцыг хадгалах**

Талууд нь мэдээллийн нууцыг гэрээ дуусгавар болсон цуцлагдсан эсэхээс үл хамааран хугацаагүйгээр хадгалж, хамгаална. Энэхүү үүргээ аль нэг тал зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.

**14. Нэмэлт өөрчлөлт, Хавсралт**

Нэмэлт өөрчлөлт, хавсралт нь талууд бичгээр харилцан тохирч, талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж тамга дарсанаар хүчин төгөлдөр болж, гэрээний салшгүй хэсэг байна.

Гэрээнд заасан өдрөөр хүчин төгөлдөр болно гэдгийг хүлээн зөвшөөрч,

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Борлуулалт, хэрэглэгчийн үйлчилгээний газрын дарга

Нэр: У.Эрдэнэзэмбэ

Байгууллага хариуцсан худалдааны менежер

Нэр: Ц.Оюунжаргал

ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
Албан тушаал: Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн Аюулгүй байдал, хяналт шалгалт, нууцын албаны ахлах ажилтан, ахлах комиссар

Нэр: Ц.Гомбодорж

Гэрээг хянасан:
Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн Хуулийн зөвлөх, комиссар

Нэр: З.Энхтайван

Since 1997
ITZONE
Accelerate Your Success

IZSLS/16/169

## IZSLS/16/169 ТООТ ГЭРЭЭНИЙ ХАВСРАЛТ

| ҮЗҮҮЛЭЛТ | АГУУЛГА БУЮУ ТОХИРСОН ЗҮЙЛ |
|---|---|
| Бараа | **PowerEdge R830 Server**<br>CPU : 2x Intel Xeon E5-4627 v4 2.6GHz,25M Cache,8.0GT/s QPI 10C/10T,No HT,Turbo (135W) Max Mem 2400MHz<br>Chassis with up to 8, 2.5" Hard Drives<br>Memory : 8x32GB RDIMM, 2400MT/s, Dual Rank, x4 Data Width<br>iDRAC8 Express, integrated Dell Remote Access Controller, Express<br>3x400GB Solid State Drive SATA Write Intensive 6Gbps 2.5in Hot-plug Drive, S3710<br>PERC H730 RAID Controller, 1GB NV Cache<br>QLogic 2562, Dual Port 8Gb Optical Fibre Channel HBA<br>No Internal Optical Drive<br>NEMA 5-15P to C13 Wall Plug, 125 Volt, 15 AMP, 10 Feet (3m), Power Cord<br>Single, Hot-plug Power Supply (1+0), 750W<br>C13 to C14, PDU Style, 12 AMP, 13 Feet (4m) Power Cord, North America<br>Broadcom 5720 QP 1Gb Network Daughter Card<br>No Operating System<br>ReadyRails Sliding Rails Without Cable Management Arm<br>RAID 5 for H330/H730/H730P (3-16 HDDs or SSDs)<br>Тоо ширхэг : 2 ширхэг |
| Нийлүүлэх хугацаа | Захиалга авснаас хойш хуанлийн 7 хоногт буюу 2016 оны 11 сарын 9 -ны өдөрт багтаан худалдан авагчид бүрэн хүлээлгэн өгнө. |
| Хүлээн авах газар | Авлигатай тэмцэх газрын байр |
| Нийт үнэ төлбөр | 64,792,788 /Жаран дөрвөн сая долоон зуун ерэн хоёр мянга долоон зуун наян найм/ төгрөг |
| Урьдчилгаа төлбөр | 40 хувь буюу 25,917,115 /Хорин таван сая есөн зуун арван долоон мянга нэг зуун арван таван/ төгрөгийг Гэрээ байгуулсанаас хойш ажлын 2 өдөрт багтаан Худалдаа хөгжлийн банкны 499026123 тоот дансанд тушаана. |
| Үлдэгдэл төлбөр | 60 хувь буюу 38,875,673 /Гучин найман сая найман зуун далан таван мянга зургаан зуун далан гурван/ төгрөгийг бараа хүлээн авсан өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан Худалдаа хөгжлийн банкны 499026123 тоот дансанд тушаана. |
| Нийлүүлэх хугацаа | Гэрээ байгуулагдсанаас хойш/ хуанлийн 6 хоногийн дотор |
| Баталгаат хугацаа | Барааг худалдан авагчид нийлүүлсэн өдрөөс хойш 3жил |
| Худалдагчийн данс | Худалдаа хөгжлийн банк 499026123 |

Талуудын гарын үсэг

Худалдан авагч: ______________ Худалдагч: ______________